

2001оны 9-р сарын 11ны өдөр

9.11ны дайралт



Дэлхийн худалдааны төв шатаж байгаа дүр зураг; Пентагон дахь нуралт; [Нислэг 175](#) ын сүйрэл 2 WTC;

Байршил New York Хот; [Arlington муж, Virginia](#); болон [Shanksville-той ойролцоо, Pennsylvania](#).

Өдөр Мягмар, 9-р сарын 11, 2001
8:46 – 10:28 ([UTC-04:00](#))

Дайралтын [Онгоц болон нийтийн](#)
хэв маяг [ЭЗЭМШЛИЙН газрын](#)

хулгай, амиа золиослогчдын
дайралт, террорист халдлага

Нас барсан 2,996
хүний тоо

Бэртсэн хүний 6,000аас илүү
тоо

Буруутан Osama bin Laden-аар
удирдуулсан Al-Qaeda
бүлэглэл

2011оны 9-р сарын 11ны өдөр Америкийн нэгдсэн улсын Newyorkболон Вашингтон хотуудад амиа золиослогчдын бүлэглэл дайралт хийсэн. Мягмар гаригийн өглөө, Al-Qaeda бүлэглэлийн 19 террорист онгоцонд байсан 4н зорчигчдыг барьцаалсан. Алан хядагчид 2 онгоц дэлбэлж,хоёрхон цагийн дотор Newyorkхотын Дэлхийн худалдааны төв болох ихэр цамхагийг сүйрүүлсэн. Түүнийхээ дараа Пентагонтой ойролцоо Vergeniaболон Arlington-ны орчим Америкийн агаарын нислэг 77-г сөнөөсөн. Тэдний хийсэн 4дөх үйл ажиллагаа ньShanksville-тэй ойролцоо Pennsylvania-д Нэгдсэн улсын агаарын нислэг 93-ийг сөнөөсөн. Энэ дайралтны үеэр 3000орчим хүн амиа алдсан.2004 онд Al-Qaeda бүлэглэл болон Osama bin Laden-г буруутгаж энэ дайралтын үүрэг хариуцлагыг хүлээх ёстой гэж үзсэн. Гэвч Al-Qaeda бүлэглэл болон Osama bin Laden энэ дайралтыг Israil, Saudi Arab болон Iraq-аас дэмжлэг авснаа мэдэгдсэн. Олон хотууд терроризмын эсрэг хууль тогтоомж боловсруулж, өргөтгөж байгаа боловч энэ зүйлээс мултарч гарч чадахгүй байна. 2011оны 5-р сард маш олон жилийн дараа Osama bin Laden-г алагдсан байхыг олсон.

Энэ сүйрэл нь дэлхийн эдийн засагт маш том гарз хохиролыг авчирсан. Дэлхийн худалдааны төвийг 2002 оны 5-р сард бүрэн цэвэрлэж дууссан ба тэр жилдээ дахин засварлагдан Пентагонд баригдсан. Олон тооны дурсгалын хөшөөнүүд байгуулагдсан ба 9-р сарын 11ны өдрийг үндэсний дурсгалт өдөр болгож Пентагоны дурсгал нэртэйгээр Newyork хотод музей байгуулсан ба түүний яг зэргэлдээ дахин нэг Дэлхийн худалдааны төв 2013 онд байгуулахаар төлөвлөгдсөн.

Агуулга

1. Дайралт

- Тухайн үе

- Золгүй явдал

- Сүйрэл

2. Алан хядагчид ба тэдний шалтгаан

- Al-Qaeda

- Osama bin Laden

- Khalid Sheikh Mohammed

- Дайрах төлөвлөгөө

- Бусад Al- Qaeda-ийн гишүүд

3. Урт хугацааны нөлөөлөл

- Эдийн засгийн өөрчлөлт

- Эрүүл мэндийн нөлөөлөл

4. Дахин сэргээлт

5. Дурсгал

Дайралт



2001.9.11нд болсон террорист халдлагын үед барьцаалагдсан онгоцны жим



Америкийн агаарын BOENG [767-200ER](#), Нислэг 11

2001.9.11ны өглөө эрт 19н барьцаалагчид Boston, Massachusetts, Newark, New Jersey болон Washington-оос Los Angeles-эсвэл San Francisco хүрч явсан худалдааны онгоцыг агаарын замд нь гартаа авсан. Онгоц маш урт нислэгийн дараагаар дээрэмдэгдсэн учир нь маш их хэмжээний шатахуунтай явж байсан.

Энд дөрвөн онгоц хамрагдсан:

Америкийн агаарын нислэг 11: Logan онгоцны буудлаас 7:59д хөдөлж Los Angeles-ын замд 5 барьцаалагчид оролгүйгээр онгоцны багийн 11 хүн, 76 зорчигчийн хамт явж байсан. Барьцаалагчид 8:46д дэлхийн худалдааны төвийн хойд хэсэгт сүйрэл болсон..

Нэгдсэн улсын агаарын нислэг 175: Logan онгоцны буудлаас 8:14д хөдөлж Los Angeles-ын замд 5 барьцаалагчид оролгүйгээр онгоцны багийн 9 хүн, 51 зорчигчийн хамт явж байсан. Барьцаалагчид 9:03д дэлхийн худалдааны төвийн өмнөд хэсэгт сүйрэл болсон.

Америкийн агаарын нислэг 77: Вашингтоны Dulles олон улсын онгоцны буудлаас 8.20д баруун Virginia-руу хөдөлж Los Angeles-ын замд 5 барьцаалагчид оролгүйгээр онгоцны багийн 6 хүн, 53 зорчигчтойгоор явж байсан. Барьцаалагчид 9:37д Пентагоны ойролцоо сүйрэл болсон.

Нэгдсэн улсын агаарын нислэг 93: Newark олон улсын онгоцны буудлаас 8:42д хөдөлж San Francisco-ын замд 4 барьцаалагчид оролгүйгээр онгоцны багийн 7 хүн, 33 зорчигчийн хамт явж байсан. Дараа нь зорчигчид бослого гаргаж Shanksville, Pennsylvania-тай ойролцоо 10:03д сүйрэл болсон.

Тэр мөч



Нэгдсэн улсын агаарын нислэг 175-ын өмнөд хэсгийн сүйрэл

8:46д 5н алан хядагчид Дэлхийн худалдааны төвийн хойд хэсгээр Америкийн агаарын нислэг 11-ээр сүйрэл хийсэн ба 9:03д өөр 5н алан хядагчид нэгдсэн улсын агаарын нислэг 175-ээр Дэлхийн худалдааны төвийн өмнөд хэсгээр сүйрэл болсон. Таван алан хядагчид 9:37д Америкийн агаарын нислэг 77-оор Пентагоноос ниссэн. Дөрөвдөх нислэг нь Shanksville, Pennsylvania-тай ойролцоо Pittsburg-ийн зүүн өмнө зорчигчид алан хядагчидтай тэмцэлдэж 10:03 минутанд сүйрэл болсон. Нислэг 93-ийн сүүлийн төлөвлөгөө нь Цагаан ордныг буулгаж авах байсан. Нислэг 93-ийн онгоцны багийн дуу хураагчаас илрүүлсэн бөгөөд зорчигчид алан хядагчдаас онгоцны удирдлагыг булаан авсаны дараа барилгыг мөргөсөн. Эхлээд алан хядагчид зорчигчидтой тэмцэлдэж байх үед онгоцны удирдлага алдаж онгоц сүйрсэн.



Пентагонд болсон нислэг 77-ийн сүйрэлийн чимээ. Эхэлснээс ойролцоогоор 86 секундын дараах бичлэг.

Зарим зорчигчид болон онгоцны багийн гишүүд онгоцны утсаар ярих кабин болон гар утсаараа тусламж дуудах боломжтой байсан ба онгоцонд байсан алан хядагчидруу нулимс асгаруулагч хий, перц зэргийг цацаж байсан. Эсэргүүцэл үзүүлсэн хүмүүсийг алж, зарим хүмүүсээр барлаг хийж байсан. 9.11ны комиссын мэдэгдсэнээр тэд олон хөдөлгүүрт гар хэрэгсэлтэй, их хэмжээний зэвсэгтэй явж байжээ. Нислэг 11,175,93-г алан хядагчид тэрэх

бөмбөг авч явж байсан гэж зорчигчид нь мэдэгдсэн боловч нэг зорчигч үүнийг худал гэж мэдүүлсэн. FBI-аас сүйрэл болсон газраас тэсрэх бөмбөгний ул мөр олдоогүй ба магадгүй тэсрэх бөмбөг байсан нэх мэдээлэл худал байх гэж мэдэгдсэн. Дэлхийн худалдааны төвийн гурван барилга нурсан нь маш том гарз хохирол авчирсан. 9:59-д өмнөд хэсэг нь нурж дараа нь Нэгдсэн улсын агаарын нислэг 175 мөргөсний улмаас 56 минутын дараа бүрэн шатаж дууссан. Хойд хэсэг нь 102 минутын дараа буюу 10:28-д нурсан. Хойд хэсгийг нурах үед түүнтэй ойролцоо байсан Дэлхийн худалдааны төв 7 дээр хэлтэрхийнүүд нь унаж улмаар шатаж эхэлсэн. Энэ гал бүтэн цагийн турш үргэлжилж 5:21-т бүрэн нурсан.

1989 оны нислэгийн үеэр алан хядагчид халдаж байсан боловч хүрч явсан газраа буюу Cleveland, Ohio-д аюулгүй газардсаж байсан.

Золгүй явдал



2001.9.13ны өдрийн Шатсан барилга байгууламжны дүр зураг



1өдрийн дараа дэлхийн худалдааны төв 6,7,1- ийн үлдсэн байдал

Энэ дайралтын улмаас нийтдээ 299 хүн үхсэн ба үүний дотор 19 алан хядагчид 2977 хохирогч байжээ. Энд 246 хүн нь онгоцонд зорчиж явсан хүмүүс 2606 хүн нь Newyork хотын хүмүүс, 125 нь Пентагоны иргэд байжээ. Нас барагсдын ихэнх хувь нь жирийн иргэд; Пентагонд алагдсан хүмүүсийн 55 нь цэргийн албан хаагч байжээ.

Цамхагийн хойд хэсэгт 1355 хүн мөргөлдөөний үеэр утаанд бүтэж цамхагас гарахыг оролдож байсан боловч эцэст нь барилга нуран унасан. Энэ үеэр зөвхөн 107 хүн л амьд үлдэж чадсан. Өмнөд хэсэгт болсон мөргөлдөөнөөс 18 хүн амьд үлдэж 630 хүн амиа алдсан.



Newyorkхот дахь дэлхийн худалдааны төвийн үлдэгдэл

200гаруй гудамж талбайд явж байсан хүмүүс зэргэлдээ барилгуудын нурангинд дарагдсан. Мөн түргэн тусламжийн 411 ажилчид нас барсан. Newyorkхотын гал унтраах ажиллагаанд 341 гал унтраагч , цагдаагийн ерөнхий газрын 23 офицер, хилийн цэргийн 37 офицер амиа алдсан. Мөн 8н түргэн тусламжийн ажилтан, нэг хувийн үйлчилгээнд явж байсан түргэн тусламжийн ажилтнууд амиа алдсан. ДХТ-ийн хойд хэсэгт 101-105давхарт байрлаж байсан Cantor Fitzgerald-ийн хөрөнгийн банкны 658 ажил олгогч, Marsh Inc.,-ийн 93-100давхарт байрлаж байсан тус банкны 358ажилтан болон Aon корпорацийн 175 ажилтан амиа алдсан.

Нас барсан хүний тоо (алан хядагчдыг оруулахгүйгээр)

| | | |
|--------------|--|---------------------------|
| New York хот | Дэлхийн худалдааны төв | 2,606 ^{[34][53]} |
| | Америкийн 11 | 87 ^[54] |
| | Нэгдсэн улсын 175 | 60 ^[55] |
| Arlington | Пентагон | 125 ^[56] |
| | Америкийн 77 | 59 ^[57] |
| Shanksville | Нэгдсэн улсын 93 | 40 ^[58] |
| Нийт | | 2,977 |

Хор уршиг



2001оны 9-р сарын 17ны агаараас авсан зураг



Пентагонд болсон сүйрэлийн улмаас үүссэн нуранги

Ихэр цамхаг, олон тооны Худалдааны төвийн барилга болон Nicholas Greek Orthodox-ын сүм сүйтгэгдсэн. Хойд, Өмнөд цамхаг, Marriott зочид буудал (ДХТ3) болон ДХТ7 үндсэндээ сүйрсэн. Дэлхийн худалдааны төвийн 4,5,6-р барилгууд ч явган хүний замаар холбогдсон байдаг учир нэлээд хохирол амссан. 130-р эрх чөлөөний гудамжинд байрлах Deutsche банкны барилга сүйрэлд өртөж дараа нь нурсан. Дэлхийн санхүүгийн төвийн 2 барилга нэлээд хохирол амссан. Дэлхийн худалдааны төвөөс Liberty гудамжны Deutsche банкны барилга хүртэлх хэсэгт ямар ч хүнгүй болсон учир нь тэр газарт маш хортой нөхцөл байдал үүссэн байсан. Manhattan-ы харилцааны коллеж сүйрэлийн үеэр их хэмжээний хохирол амсч дахин баригдсан. Хөрш зэргэлдээ барилгууд халдлагад нэлээд өртсөн ба түүний дотор 90-р өргөн чөлөөний Verizon барилга өртсөн хэдий ч дахин сэргээн засварлагдсан. Дэлхийн санхүүгийн төвийн барилга, One liberty plaza, 90-р гудамжны сүм нэлээд халдлагад өртсөн хэдий ч дахин сэргээн засварлагдсан.

Алан хядагчид ба тэдний шалтгаан

Al-Qaeda

Зөвлөлт холбоот улс Афганистанруу довтлох үед 1979 онд Al-Qaeda бүлэглэл анх үүссэн. Удалгүй, Osama bin Laden Афганистанруу аялж, Arab-ийн Mujahideen-аас зөвлөлт холбоот улсыг эсэргүүцэх тухай тусламж хүссэн.

Osama bin Laden



Osama bin Laden-ы 1997 онд авахуулсан зураг

Bin Laden-г зохион байгуулттай дайралтанд хамгийн анх сэжиглэж байсан ба дараа нь хэргээ хүлээсэн.

Khalid Sheikh Mohammed



2003 онд Пакистанд авахуулсан Khalid Sheikh Mohammed-ы зураг

Арабийн Al Jazeera телевизээр 2002 оны 4-р сард сэтгүүлч Yosri Fouda Khalid Sheikh Mohammed, Ramzi bin al-Shibh-ийн хамт тухайн үеийн хэрэгт холбоотой гэдгээ хүлээн зөвшөөрсөн. Mohammed 9.11-ны дайралтанд оролцсон шалтгаанаа Нэгдсэн улстай өс хонзонтой байсантай холбон тайлбарлажээ. Mohammed Дэлхийн худалдааны төвийн бөмбөгдөх үйл ажиллагаанд зөвлөгөө өгч түүний санхүүд нь тусалж байсан хүн бол авга ах Ramzi Yousef байсан ба дайралтны бөмбөгдөх үйл ажиллагааг хариуцаж байсан. Mohammed 2003 оны 3-р сарын 1нд баривчлагдсан.

Дайрах төлөвлөгөө



Дэлхийн худалдааны төвийн дайрах газрын зураг



Дэлхийн худалдааны төвийн дайрах төлөвлөгөө диаграммаар үзүүлсэн нь

Khalid Sheikh Mohammed анх энэ дайралтын санааг гаргасан бөгөөд Osama bin Laden-д 1996 онд санал болгосон. Яг тэр үед Bin Laden, Al Qaeda бүлэглэлийг үүсгэн байгуулаад байсан бөгөөд Sutan-аас Афганистан руу буцаж ирсэн үе нь таарсан. 1998 оны 12-р сард CIA-гаас ерөнхийлөгч Bill Clinton, Al Qaeda бүлэглэл Америкийн нэгдсэн улсаас онгоц барьцаалж магадгүй тухай мэдээлэл авсан. 1998 оны сүүлээр эсвэл 1999 оны эхээр хийе гэсэн Mohammed-ийн төлөвлөгөөг Bin Laden болон түүний туслах Mohammed Atef зөвшөөрч 1999 оны эхээр хийхээр энэ дайралтыг хийхээр хуйвалдаан зохиож байсан боловч, Bin Laden, Mohammed-ын энэ санааг гэнэт цуцалсан. Los Angeles-ын Америкийн төв банкны барилгыг эзэлж авахад тэдэнд хангалттай боломж бололцоо байгаагүй. Тэдэнд энэ төлөвлөгөөнд бэлдэхэд маш бага хугацаа байсан. Bin Laden санхүүгийн баттай эх үүсвэр болон итгэлтэй хүмүүсийг хайж байсан. Bin Laden, Bosnia-д тэмцэлдэж байсан 2 туршлагатай хүнийг олсон ба тэдгээр нь Nawaf al-Hazmi, Khalid al-Mihdhar нар байлаа. Hazmi болон Mihdhar нар Америкийн нэгдсэн улсаас 2000 оны 1-р сарын дундуур хүрч ирсэн. 2000 оны хавар, Hazmi болон Mihdhar маш хүч чадалтай хүмүүс байсан хэдий ч англи хэлээр маш муу ярьдаг нислэгийн ур чадвар нэлээн муу байсан. 1999 оны сүүлээр Хамбург, Германаас хэсэг залуусыг Афганистанд авчирсан. Үүнд Mohammed Atta, Marwan al-Shehni, Ziad Jarrah ба Ramzi bin al-Shibh нар багтаж байсан. Bin Laden тэднийг сонгосон шалтгаан нь тэд маш боловсролтой, англи хэлээр сайн ярьдаг, өрнө зүгийн туршлагатай эрчүүд байсан. Шинэ гишүүд нэмэгдүүлснээр тэдний хүч нөлөө улам ихсч Al Qaeda бүлэглэлийн удирдагчид Hani Hanjour-ын худалдааны хөлөг онгоцны эрхийг аль хэдийнээ олж авч чадсан. Hazmi, San Diego-гоос Hanjour-т 2000 оны 12-р сарын 8нд хүрч ирсэн. Hanjour-т хэсэг хугацаанд сургуулилт хийсний эцэст, тэд удахгүй Arizona-д үлдсэн. Marwan al-Shehni 2000 оны 5-р сарын сүүлээр, Atta 2000 оны 6-р сарын 3нд, Jarrah 2000 оны 6-р сарын 27нд хүрч ирсэн. Bin al-Shibh хэд хэдэн удаа Америкийн нэгдсэн улсад хууль ёсны дагуу ирсэн бөгөөд харин Yemen-гийн виз нь маш удаж байсан тул тэр хууль бусаар цагаачилж орж ирсэн. Bin al-Shibh, Hamburg-т үлдэж Atta болон Mohammed бусад ажлыг зохицуулж байсан. Өмнөд Florida-гаас онгоц авах ажлыг Hamburg шоронд

байгаа тэдний гишүүд хийж гүйцэтгэсэн. 2001 оны хавар, хоёр дахь алан хядагчид Америкийн нэгдсэн улсаас хүрч ирж эхэлсэн. 2001 оны 6-р сард, Atta Испанид al-Shibh-тай уулзаж тэд төлөвлөгөөгөө боловсруулж дараа нь эцсийн үйл ажиллагаагаа хийсэн. Bin Laden-тай уулзаж удахгүй дайрахад бэлэн болсон тухайгаа хэлсэн.

Бусад Al-Qaeda бүлэглэлийн гишүүд

Энэ үйл ажиллагаанд оролцсон 5н голох хүн бол Bin Laden, Khalid Sheikh Mohammed, Ramzi bin al-Shibh, Abu Turab al-Urduni and Mohammed Atef нар байсан. 2005 оны 9-р сарын 26нд Al-Qaeda бүлэглэлийн гишүүдийг 9.11ны хэрэгт буруутгаж Испаний дээд шүүхээс Abu Dandah-т 27 жилийн хорих ял оноосон. Яг адил үед, өөр 17 Al-Qaeda бүлэглэлийн гишүүдэд 6-11жилийн хорих ял оноосон. 2006 оны 2-р сарын 16нд Испаний дээд шүүхээс Abu Dandah-т оноосон ялаа 12 жил болгож багасгасан учир нь энэ хэрэгт холбоотой гэдгийг яг баталж чадаагүй. Мөн 2006онд, Moussaoui-г магадгүйтеррористхалдлагаболонгаарындээрэмтэйхолбоотой 20 дахьаланхядагчбайхгэжүзсэн. Mounir el-Motassadeq-ийг Gamburg-ийн алан хядагчидтай холбоотой гэж тухайн үедээ үзэж байсан .

Эдийн засгийн нөлөө



9.11ны дараах Newyorkхотын эдийн засгийн өөрчлөлт


Энэ дайралтын дараагаар Америкийн нэгдсэн улс төдийгүй Дэлхийн зах зээлд ч маш хүчтэй нөлөө үзүүлсэн. Валют арилжааны төв 9.11- 9.17-ыг хүртэл ерөнхийдөө хаалттай байсан. Dow Jones-ын үйлдвэр (DJIA) дунджаар 8921-684 болтлоо хувьцаа нь унасан. Энэ бол нэг өдрийн их хэмжээгээр унасан анхны үзэгдэл юм. Долоо хоногийн төгсгөлд, DJIA-ийн хувьцаа 14.3%-иар дахин унасан. Америкийн нэгдсэн улс 7 хоногийн дотор \$1,4триллионы алдагдал хүлээсэн.

Newyorkхотод 430000 иргэн ажилгүй болж, дайралтын дараах 3 сард 2,8\$ тэрбумын орлогыг алдсан. Эдийнзасагт үзүүлсэн нөлөөлөлд экспортын асуудал хүндээр хөндөгдөж байсан . 2001 оны сүүлийн 3н сар болон 2002 онд Newyork-ын GDP 27.3\$ тэрбумаар унасан. Америкийн нэгдсэн улсын засгийн газраас 2001 оны 9-р сард болсон явдалд тусламж болгож 11.2\$ тэрбум, 2002 оны эдийн засгийн хөгжил болон дэд бүтцэд зориулж 10.5\$ олгосон. Дэлхийн худалдааны төвтөй ойролцоо Lower Manhattan-ы жижиг бизнес эрхлэгчид болох 18000 иргэд сүйрэлийн улмаас амьдралаа залгуулах эх үүсвэрээсээ салсан. Жижиг дунд бизнес эрхлэгчдийн холбооноос зээл олгож , засгийн газраас мөнгөн тусламж үзүүлсэн. Lower Manhattan-ы 2,960,000m²талбай бүхий барилга нурсан.дайралтын дараа Хойд Америкт урт хугацааны турш агаарын тээвэр хаалттай байсны эцэст дахин нээгдсний дараа агаарын тээврээр үйлчлүүлэх иргэдийн тоо 20%-иар буурсан нь эдийн засгийн асуудлыг улам хурцатгаж байсан.

Эрүүл мэндийн нөлөөлөл



Амьд үлдсэн хүмүүс цамхагийн нурангинаас үүссэн хортой тоосонцорт их хэмжээгээр хордсон



Цамхагаас унасан хэлтэрхий болон тоосонцорыг микроскопоор харсан зураг

Ихэр цамхаг 2500 гаруй контаминант агуулж байсан нь мянга мянган хортой хэлтэрхийнүүд үүсэх нөхцөл бүрдэж байсан. Үүнээс үүдэж тамирдах буюу доройтох өвчин үүсч байсан. Хүрээлэн буй орчныг хамгаалах төвөөс агаарын чанарыг тогтоох хэрэгтэй гэж үзэж байсан боловч 2002 оны 6-р сар хүртэл тэд энэ ажлыг хийж чадаагүй. Хятад хороололтой ойролцоо хэсгийн газар болон Lower manhattan-ы ажилчид, сурагчид, тэндхийн уугуул иргэд эрүүл мэндээрээ

маш их хохирсон. Дэлхийн худалдааны төвийн нуралтаар амь үрэгдэгсдийн дотор хорт хийнд хордсон хүмүүс ч нэлээн их байсан. Ойролцоогоор 18000 хүн хортой тоосонцороос болж өвчилсөн. Тиймээс ДХТ-ын уналтын дараа бага насны хүүхэдтэй эхчүүд болон жирэмсэн эхчүүдийг гэртэйгээ ойрхон ажиллахыг зөвлөж байсан.

Дахин сэргээлт



[Дэлхийн худалдааны төвийн дахин сэргээсэн барилга](#) (2011. 10. 07-д авсан зураг)

Дайралтын дараа Newyorkхотын захирагч Rudy Giuliani “ Бид дахин барих болно. Бид удахгүй цэрэг зэвсгийн, эдийн засгийн хүчээрээ улам илүү болох болно. Дахин нэг тэнгэрт тулсан барилга барих болно” гэж зарлаж байсан. Дайралтаас яг нэг жилийн дараа сүйрсэн Пентагон дахин баригдсан. 7 Дэлхийн худалдааны төвийн эхний ээлжийн барилга 2003 оны сүүлээр нээгдэж, шинэ барилга нь 2006 онд бүрэн ашиглалтанд орсон. 1 Дэлхийн худалдааны төв одоогоор баригдаж байгаа бөгөөд 2013 онд 541м өндөр барихаар төлөвлөж байна, энэ нь хойд Америкийн хамгийн өндөр барилга болно.

Дурсгал





2011.11.09нд дайралтаас хойшх 10 жилийн ой. Дэлхийн худалдааны төв 1-ээс улаан, цагаан, цэнхэр өнгийн гэрэл асаасан байдал

Дайралтын дараа, дэлхийн эргэн тойронд энэ өдрийг хүндэтгэсэн олон дурсгалууд бий болсон. Нэмж хэлэхэд, хүмүүс Ground Zero-ийн эргэн тойронд нас барагсдыг санан дурсаж зургийг нь авчирч байрлуулдаг. Тэдгээрийг харсан хүмүүс “ эдгээр нас барсан хүмүүс бол ямар ч гэм зэмгүй иргэд” гэдгээс өөр зүйл хэлж чадахгүй байлаа. Тэдгээр зурагнууд хаа сайгүй, утасны корпус. Гудамжны гэрэл, метроны буудлын самбар гээд л. Том гашуудлын дараа хүмүүс хэсэг хэсэг дуугаа хурааж уйтгарлаж байсан ч тэд аз жаргалтай байсан. Өмнө нь, Newyork хот хүйтэн хөндий байсан бол одоо бие биендээ тусалж дэмждэг болсон.

Пентагоны дурсгал нь дайралтаас хойшхи 7 дахь ойн баяр буюу 2008 онд нээгдсэн. Энэ нь Пентагоны зурагтай 184 хавтанг газарт байрлуулсан парк юм. 2001-2002 онд барилгыг дахин засварлаж байх үед , жижиг сүм байгуулж дотор нь дурсгалыг байрлуулсан.

Shanksville-ийн дурсгалын газар үймээн болсон газраас 457м-ийн зайд байрладаг.Өөр олон газар дурсгалын байгууламжуудыг байгуулсан. Жил бүрийн ойн баяраар Newyorkхотод гунигын дуу эгшиглүүлж, нас барагсдын нэрийг дууддаг. Америкийн нэгдсэн улсын ерөнхийлөгч Пентагоны дурсгалд оролцдог.